

Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын Ажлын хэсгийн хуралдааны тэмдэглэл

Ажлын хэсгийн хуралдаан 2010 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн 14 цагт Уул уурхайн үндэсний ассоциацийн хурлын танхимд эхлэв.

Ажлын хэсгийн хуралдаанд Ерөнхий сайдын ахлах зөвлөх, Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга, Ажлын хэсгийн ахлагч Б.Долгор, ажлын хэсгийн гишүүд Сангийн яамны Нягтлан бодох, бүртгэлийн бодлогын газрын дарга С.Мягмардаш, Уул уурхайн үндэсний ассоциацийн гүйцэтгэх захирал Н.Алгаа, Нээлттэй нийгэм форумын менежер Н.Дорждарь, Засгийн газрын ахлах референт Э.Сумъяа, Ил тод сангийн тэргүүн н.Цэрэнжав, Монголын ажил олгогч эздийн холбооны гүйцэтгэх захирал Х.Ганбаатар, Төлсөн авснаа нийтэл хөтөлбөрийн зохицуулагч Д.Сэнгэлмаа, Татварын ерөнхий газрын Татварын удирдлага хамтын ажиллагааны хэлтсийн дарга Б.Эрдэнэбаатар, Татварын ерөнхий газрын Тусгай хэлтсийн дарга Я.Пүрвээ, Ашигт малтмалын газрын тасгийн дарга Д.Бямбадагва, Багануур ХХК-ийн ажилтан н.Батзориг, Петрочайнэ Дачин Тамсаг ХХК-ийн дэд захирал А.Эрдэнэдорж, Байгаль орчин аялал, жуулчлалын яамны мэргэжилтэн Н.Эрдэнэцэцэг, Нүүрс ассоциацийн ажилтан Э.Сарангэрэл, Бороо гоулд компанийн ажилтан н.Бат-Эрдэнэ, Монросцветмет ХХК-ийн ажилтан н.Билгүүнбат, Газрын тосны газрын тасгийн дарга Э.Оюун нар оролцов. Мөн хуралдаанд ОУИТБС-ын ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон, санхүүгийн ажилтан Т. Хүрэлчимэг, Улаанбаатар аудит компанийн захирал Б.Осоргарав, ахлах аудитор Н.Эрдэнэцог, Тамгын газрын дарга Л.Цэвэлмаа, аудитор Б.Мэндбаяр, Ч.Номинчулуун, Л.Сайзмаа, Б.Бат-Орших нар оролцов. Хуралд ажлын хэсгийн 25 гишүүн оролцох ёстой байсан боловч 18 гишүүн оролцож ирц 72 хувьтай байв.

Хэлэлцсэн асуудлууд:

1.Улаанбаатар аудит корпораци, Хаарт нээс аудитын компанийн консорциумын хийсэн Монгол улсын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын 2008 оны нэгдсэн тайлангийн урьдчилсан дүн /Улаанбаатар аудит корпорацийн ахлах аудитор, чанарын хяналтын хорооны дарга Н.Эрдэнэцогт танилцуулна./

2.ОУИТБС-ын олон улсын удирдах хорооны шийдвэрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний төсөл /Ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон танилцуулна./

3.ОУИТБС-ыг Монгол улсад хэрэгжүүлэх дунд хугацаа /2010-2014 он/-ны стратегийн төсөл /Засгийн газрын ахлах референт, ажлын хэсгийн нарийн бичгийн дарга Э.Сумъяа танилцуулна./

4.ОУИТБС-ын тайлан гаргах маягтуудын төсөл /Ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон танилцуулна./

Ажлын хэсгийн хуралдааныг Ерөнхий сайдын ахлах зөвлөх, Ажлын хэсгийн ахлагч Б.Долгор нээж хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулав.

Б.Долгор: Сайн байцгаана уу. ОУИТБС-ын Ажлын хэсгийн хурлыг нээж байна. Өнөөдрийн ажлын хэсгийн хуралдаа хүрэлцэн ирсэн та бүхэнд баярлалаа.

Хэлэлцэх эхний асуудал болох Улаанбаатар аудит корпораци, Хаарт нээс аудитын компанийн консорциумын хийсэн Монгол улсын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын 2008 оны нэгдсэн тайлангийн урьдчилсан дүнг Улаанбаатар аудит корпорацийн ахлах аудитор, чанарын хяналтын хорооны дарга Н.Эрдэнэцогт танилцуулна.

I.ХЭЛЭЛЦСЭН нь: Улаанбаатар аудит корпораци, Хаарт нээс аудитын компанийн консорциумын хийсэн Монгол улсын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын 2008 оны нэгдсэн тайлангийн урьдчилсан дүн Н.Эрдэнэцогт: Та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая. Манай Улаанбаатар аудит компани Их британийн Хаарт нээс компанитай хамтран консорциум байгуулж ОУИТБС-ын 2008 оны тайлангийн нэгтгэлд аудит хийхээр шалгарч ажиллаж байгаа билээ. Бид 2010 оны 3-р сараас эхлэн ажиллаж ажлын 40 хоног ажиллан, эхний байдлаар нэгтгэсэн тайланг гаргаснаа та бүхэнд танилцуулъя. /Танилцуулгыг хавсаргав./

Б.Долгор: За танилцуулгыг сонслоо. Асуух асуулт байна уу?

С. Мягмардаш: Засгийн газар тайлбарлаагүйгээс шалтгаалсан 26 тэрбумын зөрүү гэж байна. Энэ ямар учиртай вэ? Удирдлагын хариуцлагын захидалд хариуг нь зөвхөн 16 компани ирүүлсэн гэж байна. Үлдсэн 30 компани нь яагаад ирүүлэхгүй байгааг тайлбарлана уу? Гуравдугаарт, 30, 31, 32 дугаар хууданд аудиторууд Сэлэнгэ аймагт томилолтоор ажиллах үедээ Засгийн газарт хандив тусламж өгснийг дутуу бүртгэсэн байсныг тогтоосон гэжээ. Ингэхдээ, иргэдийг Утай гүмбэн явуулсан, эсхүл оюутны сургалтын төлбөр өгсөн гэх мэт иргэдэд шууд өгсөн аймаг, сумын дансаар дамжаагүй хандивуудыг Засгийн газрын авсан хандив гэж тооцсон уу? Дөрөвдүгээрт, тайлан гаргахад хариуцлагагүй хандсан компаниудад болон байгууллагуудад хариуцлагын арга хэмжээ авах тал дээр ямар саналтай байна вэ? Жишээ нь, байгаль хамгаалахад зарцуулсан зардал гэдгийг Байгаль орчны яаман дээр очиж үзэхэд, судалгааны шинжтэй материалыг тайлан дээр тавьсан нь зөрүү гарахад нөлөөлсөн байсан. Тавдугаарт, Ашигт малтмалын газар хураамжаа ам.доллараар авсан гэж байна. Монгол Улсад төгрөгөөр гүйлгээ хийнэ гэсэн хууль гарчихсан байхад ямар учраас ам.доллараар хураамж аваад байна вэ? Зургадугаарт, Татварын ерөнхий газар өөрийн базаасаа татсан мэдээллээрээ тайлан гаргасан гэжээ. Гэтэл Сангийн сайд, Үндэсний статистикийн газрын баталсан журмаар бол төрийн захиргааны байгууллагууд тайлангуудаа ТЕГ-т ирүүлж ТЕГ нэгтгэнэ гэсэн байгаа юм. Гэтэл төрийн байгууллагууд нь ирүүлэхгүй болохоор аргагүй өөрийнхөө базаас тоогоо аваад гаргаад байгаа юм. Энэ ер нь зөв юм уу?

Н.Эрдэнэцог: Эхний асуулт болох Засгийн газрын тайлбарлаагүйгээс гарсан 26 тэрбумын зөрүү нь Петролайнэ дачин тамсаг компани болон Засгийн газрын хооронд хийгдсэн газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээн дээр гарсан. Петролайнэ болохоор бид өгсөн гээд байдаг, харин Засгийн газар болохоор авсан гэсэн баримтаа гаргахгүй байсан. Гүйцэтгэх ажлын хүрээнд бид Газрын тосны газар дээр очиж үүнд тодруулга хийж, энэ зөрүү арилсан. Удирдлагын хариуцлагын захидлын хувьд гэвэл, манай консорциумын гадаад компанийн

нөхдүүд санал болгосны дагуу тухайн компанийн удирдлагуудад үнэн зөв тайлагнасан гэдгээ баталгаа болгож удирдлагын хариуцлагын захидал ирүүлээч ээ гэж хүсэлт тавьсан, одоогийн байдлаар 30 компани ирүүлээгүй, 16 нь ирүүлсэн байна. Хандив, тусламжийн тухайд гэвэл бид томилолтоор ажиллахад ийм байсан талаараа л ярьсан юм. Харин тооцохдоо бол төрийн байгууллагад өгсөн гэдгийг нь салгаж тооцсон юм. Ашигт малтмалын газрын ам.доллараар авсан хураамж бол 2008 оны тайлант хугацаанд орсон дүн юм. Хууль нь бол 2009 онд гарсан учраас хамаарахгүй юм билээ.

Б.Осоргарав: Зарим ажиглагдсан юмыг энд хэлье. Ер нь зарим компаниудын тайлан бөглөж байгаа байдал нь туйлын хангалтгүй байгаа нь ч харагдаж байсан. Жишээ нь, Монгол газар компани дээр очиж ажиллахад санхүүгийн хүмүүс нь энэ тайлангийн талаар ер мэдэхгүй инженер, геологийн ажилтнууд нь бөглөдөг байдал ажиглагдсан. Нэгэнт тайлан дээр санхүүгээс гараагүй дүн тавьсан тохиолдолд зөрүү гарах нь бол ойлгомжтой байгаа юм. Харин Байгаль орчны яамны гаргадаг тооны хувьд бид очиж ажиллахад 1 м²-ыг нь 500 төгрөгөөр үржүүлээд л гаргадаг юм билээ. Энэ талаар Эрдэнэцэцэг тайлбарлах уу?

Н.Эрдэнэцэцэг: Бид нарын хувьд яг хэдэн төгрөг үүнд зарцуулсан бэ гэдэг дээр биш хэдэн га-г нөхөн сэргээсэн бэ гэдэг дээр анраарлаа хандуулдаг байсан. Энэ жилээс гүйцэтгэлээр нь бодит дүнг авах талаар анхаарч ажиллаж байна. Мөн зарим компаниуд бидэнд өгсөн тооноосоо өөр тоог тайлан дээрээ тавьснаас болж бас зөрүү үүссэн байсан.

Б.Пүрэвээ: Энэ тайлангийн 5 дугаар хуудсан дээр сум орон нутгийн татварын байгууллагууд нь цуглуулж авсан бүх татварын дүнгээ ТЕГ-т мэдээлэхгүй байгаагаас хүлээн авсан татварын дүнд зөрүү гарч байна гэжээ. Үүнээс харах юм бол татварын байгууллага нь ер ажлаа хийдэггүй юм байна гэж харагдахаар байна. Гэтэл бодит байдал дээр сум, орон нутгийн татварын байцаагч нар оруулсан орлогоо дүгнүүлээд, тайлангаа гаргаад явуулж байгаа. Татвар, хураамж, төлбөртэй холбогдсон бүх зүйл бүртгэгдэж байгаа. Харин хандив, үйлчилгээний хураамж гэх мэтийг манайх бүртгэдэггүй.

Н.Эрдэнэцогт: Үүн дээр тайлбар хэлэхэд Бороо гоулдын түгээмэл тархацтай ашигт малтмал хэрэглэсэн төлбөр гээд 1 тэрбум гаруй төгрөгийг татвараас тодруулга хийж 3 удаа албан бичиг явуулахад гарч ирээгүй. Мөн нэр бүхий компаниудын газрын төлбөр, ус, рашаан ашигласны төлбөр гээд нэлээд хэдэн төлбөрүүдийг бид танайд нэр усаар нь явуулсан. Тэгэхэд гарч ирэхгүй байсан. Ийм учраас бид орон нутгийн байцаагч нар нь орлогоо зөв, бүрэн бүртгэхгүй байна гэсэн дүгнэлтэнд хүрсэн.

Б.Пүрэвээ: Манай дээр бүх л татварт хамаарагдах төлбөрүүд бүртгэгдэж байгаа. Харин чухам яагаад энэ төлбөрүүд гарч ирэхгүй байсныг мэдэхгүй байна. Эргээд илүү, дутуу төлөлтөө тооцно. Бүртгэгдэхгүй байна гэсэн ойлголт бол байхгүй.

Б.Осоргарав: Үүн дээр нэмээд хэлэхэд Гаалийн төлбөр гэж бас хэцүү юм байна. Бүртгэл нь гэхэд задаргаа байхгүйгээр бөөн дүнгээр л бичигддэг. Баахан юм нийлүүлээд ганцхан дүнгээр компьютертээ хийдэг. Ялгаж салгаж авна гэсэн

ойлголт бол ер нь байхгүй юм билээ. Бас бид 2, 3 удаа очиход улсын нууц гээд тоогоо өгөхгүй байсан учраас Цолмон гуай бид хэд очиж Цэвээнжав даргатай нь уулзаж байж хагас дутуу хэдэн тоо авсан. Энэ тоогоо хувилаад ноогдуулалтаар нь барагцаа маягаар тавьсан.

Б.Долгор: Дэлгэрэнгүй тайлан ирүүлээгүй компаниуд гэж байна. Дэлгэрэнгүй тайлан ирүүлснүүдийг нь тоо болгоныг тулгаж авч чадаж байна уу? Энэ тохиолдолд хэрхэн шалгаж байгаа вэ?

Н.Эрдэнэцогт: Чадаж байгаа. Эхний харьцуулалтаар бүх тоонууд нь яв, цав таарч байгаа хэдэн газар байсан. Таараагүй газруудад нь дэлгэрэнгүй тайлан гаргаач гэсэн хүсэлт явуулсан. Дэлгэрэнгүй тайлан ирүүлсэн ч бас зөрүү гарсан газар байгаа. Зөрсөн дүн болгоноор 2 талаас дахин тодруулаад явж байгаа. Үлдсэн хугацаанд энэ тодруулах үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн хийнэ. Зарим нь нягтлан нь гадаад явсан гэх мэт шалтгаанаар хүлээгдэж байгаа.

Б.Долгор: Петрожайнэ дээр маш том зөрүү гарсан. Дэлгэрэнгүй тайлан ирүүлээгүй гэсэн байна. Энэ ямар учиртай юм бэ?

Ч.Номинчулуун: Засгийн газраас ирүүлсэн дүн Петрожайнэгийн ирүүлсэн тоотой зөрөөд байгаа. Тэгэхээр яг аль тал нь зөрүүтэй мэдээлж байгаа нь тодорхой биш гэсэн үг юм. Одоо яг үлдээд байгаа дүн нь Газрын тосны газарт төлсөн төлбөрийн дүн нь зөрж байгаа, 318 сая төгрөгийн ус, рашаан ашигласны төлбөрийг Петрожайнэ төлсөн гээд тайлагнасан мөртлөө татварын ирүүлсэн дүнд байхгүй байгаа юм.

А.Эрдэнэдорж: Би Петрожайнэ компанийн төлөөлөл байна. Бид төлсөн зүйлээ баримтаар аваад ирсэн. Төлсөн юм чинь Засгийн газарт байх л ёстой шүү дээ. Ноднин ч гэсэн газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу төлсөн мөнгө алга болчихоод л байсан шүү дээ. Ер нь төлсөн нь баримттай байхад авсан нь яагаад бүртгэгдэхгүй байдаг юм бэ?

Ш.Цолмон: Түрүү жилийн тэр алга болсон гээд байгаа төлбөр чинь он дамжигдсан гэдэгт орчихоод зөрөөд байсан. Энэ жил тийм он дамжсан гэхээр юм байхгүй биз дээ.

Б.Осоргарав: Ийм дутуу бүртгэл байгаад болохоор бид тайландаа орон нутгаас дутуу бүртгэл хийж байна гэж бичээд л байгаа юм.

А.Эрдэнэдорж: Бас би хандив тусламжийн талаар хэлэхэд, компани Засаг даргын шахалтаар л иргэдэд хөрөнгө мөнгөөр тусалж байгаа шүү дээ. Тэгэхээр энэнийг Засгийн газрын гэдэг дээр бүртгэхээс өөр арга байхгүй байгаа юм.

С.Мягмардаш: Хандив тусламжийн хувьд татварын урсгалаас өөр маягаар бүртгэгдээд байгаа учраас хүндрэлтэй байна. Өөрөөр хэлбэл сумын Засаг дарга хандиваа ТЕГ-т ирүүлнэ гэсэн байгаа, харин татвар бол аймаг дээрээ нэгтгэгдэж байж ТЕГ дээр ирдэг шүү дээ. Агентлагуудын хувьд ч адилхан. Шууд ТЕГ руу ирдэг учраас хяналтгүй, системгүй болоод зөрүү гараад байна уу гэж харагдаж байна. Мөн хандив өгөхдөө морины уралдааныг ч юмуу манай компани байлна гээд хүрч ирээд байлчихдаг. Тайлагнахдаа сумд өгсөн хандив тусламж гээд бүртгэчихдэг. Иймэрхүү зүйлүүдээс болоод бас зөрчил үүсээд байна.

Н. Дорждарь: Тэр дэлгэрэнгүй тайлан ирүүлэхгүй байгаа гээд байгаа жишээ нь Тавантолгой байна. Орон нутгийн өмчийн компани шүү дээ. Санаачлагын тайлан ирүүлэхгүй байгаа талаараа ямар тайлбар ирүүлж байгаа вэ?

Н.Эрдэнэцогт: Тавантолгойн хувьд 3 удаа захидал явуулсан. Нягтланг нь хотод байхад нь дуудаж уулзсан. Бүх юмаа очингуутаа хийгээд өгнө гэж амласан. Очоод баахан шалтаг хэлсэн, одоо бол утсаа ч авахаа болисон байгаа. Утас нь бас холбогдох боломж тааруу, сүлжээ барьдаггүй газар байгаа болохоор тэр бүр холбоо барих боломж таарахгүй нь бас хүндрүүлж байна. Үлдсэн хугацаанд хүн явуулдаг юм билүү гэж бодож байгаа.

С.Мягмардаш: Ерөнхийд нь аудитын тайланг урьд жилийн тайлангуудаас сайн болсон байна, үүн дээрээ ажилласан байна гэж үзэж байна. Гэхдээ гүйцээж хийх зүйлүүд бас нэлээд их байна. Тухайлбал, сүүлд ирсэн тодруулгуудыг нэмж оруулах, аудитын зөрүүний эцсийн дүн бол өнгөрсөн жилийн аудитын 775 сая төгрөгөөс хэрхэвч илүү гаргахгүй байхаар тооцох ёстой, хийсэн ажлаа нарийсгаж аж ахуйн нэгжийн төлсөн татвар, татварын дүн 2-ын зөрүүг маш сайн олох ёстой, хайхрамжгүй хандаж байгаа компаниудад хариуцлага тооцох талаархи саналыг тайлан дээрээ тодорхой оруулж өгөх, шаардлагатай гэж үзэж байгаа бол тодорхой байгууллагууд дээр нарийвчилсан шалгалт оруулах саналаа бичих хэрэгтэй байна.

Д.Сэнгэлмаа: Надад нэг асуулт байна. Эрдэнэт үйлдвэр, Бороо гоулд компани ТББ-дад хандив тусламж өгсөн гэж байна. Ямар байгууллагуудад өгсөн юм бол?

Н.Эрдэнэцогт: Эрдэнэт үйлдвэр болон Бороо гоулд компаниуд спортын голдуу байгууллагууд, тухайлбал, Боксийн холбоо, Бадминтоны холбоо, Чөлөөт бөхийн холбоо гэх мэт байгууллагуудад хандив тусламж өгсөн байсан. Мөн Менежментийн холбоонд хандив өгсөн байсан. Гэхдээ энэ байгууллагуудад өгсөн хандивыг орон нутагт өгсөн гэдгээс нь хасч тооцсон байгаа.

Б.Долгор: Гишүүдэд шийдвэр дээр санал байна уу?

Э.Сумъяа: Хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг гарчихсан байгаа. Энэ тухай тушаалыг би аудиторуудад өгье. Мөн хандив тусламжийн талаар Сангийн сайдын журам гарсан байгаа. Тэгэхээр эрх зүйн орчныг бүрдүүлэх гээд 2 дугаар тайлан дээр зөвлөмж гарсны дагуу дээрх арга хэмжээнүүд хийгдэж байгаа. Тэгэхээр та нарын эрх зүйн орчин бүрдүүлэх гээд тайлан дээрээ бичсэн байгаа нь бидний энэ ажлуудыг үгүйсгэсэн юм шиг харагдаж байгаа учраас үүнийгээ бас тайлбартай бичээч ээ. Клиринг дээр байгаа он дамжсан зөрүүнүүдийг тооцоод зөвлөмжин дээрээ дараагийн аудит хийхэд анхаарна уу гээд бичээд өгнө үү. Шийдвэрийн төсөл дээр зөрүүнүүдийг бүгдийг тодруулах үүрэг өгч байгаа. Харин тэр боломжтой, бололтой гэсэн үгнүүдээ анхаараарай. За тэгээд энэ тайлангийн талаар Ажлын хэсгийн хурал дээр дахиж хэлэлцэх үү гэдгээ ярилцъя. Аль эсхүл эцсийн байдлаар тайлангаа гишүүдэд тараагаад санал авах уу?

Ш.Цолмон: Би нэг тодруулга хэлье. Би энэ тайлангийн зөрүү гарсан нийт 250 орчим тохиолдлоос томоохон гэсэн буюу 20 саяас дээш зөрүүнүүдийг түүж

авсан юм. Тэгэхээр тэр зөрүүнүүдийг тодруулах үүрэг өгөөд гишүүдээсээ и-мэйлээр саналаа авчихбал яасан юм бэ? Бидэнд бас цаг бага, хийх ажил их байгаа учраас үүн дээр хугацаа хэмнээд ийм санал гаргаж байна.

Б.Долгор: За тэгвэл шийдвэртээ тэр томоохон зөрүүнүүдийг тодруул гэж оруулаад ажлын хэсгийн гишүүдэд тайланг и-мэйлээр хүргүүлж санал авахаар тогтёе. Өөр саналтай гишүүн байна уу? За байхгүй бол эхний асуудлаа дуусгая.

ШИЙДВЭРЛЭСЭН нь: 1. Тайлан гаргахад оролцсон Засгийн газрын холбогдох байгууллагууд, компаниудтай дахин харилцаж, дор дурдсан зөрүү гарсан шалтгааныг тодруулж, тайланд тусгахыг тус консорциумд зөвлөмж болгов:

1.1.Эрдэнэт үйлдвэрийн байгаль орчны арга хэмжээнд зориулсан зардал 130 сая төгрөг;

1.2.Бороо гоулд компанийн төлсөн түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр 1030,2 сая төгрөг, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр 61,7 сая төгрөг, газрын төлбөр 50,3 сая төгрөг, хандив нийт 69,5 сая төгрөг, байгаль орчны арга хэмжээнд зарцуулсан зардал 1109 сая төгрөг;

1.3.Цайрт минерал компанийн байгаль орчны арга хэмжээнд зарцуулсан зардал 1450,8 сая төгрөг;

1.4.Таван толгой компанийн гаалийн татвар 50,1 сая төгрөг, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр 297,5 сая төгрөг, хандив 380 сая төгрөг;

1.5.Болд төмөр ерөө гол компанийн гааадын мэргэжилтэн, ажилчны ажлын байрны төлбөр 63 сая төгрөг, байгаль орчны арга хэмжээнд зарцуулсан зардал 110,8 сая төгрөг, гаалийн татварын 140 сая төгрөг, хандив тусламжийн 71 сая төгрөг;

1.6.МАК компанийн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр 454,9 сая төгрөг, газрын төлбөр 21,5 сая төгрөг, ус рашааны төлбөр 52 сая төгрөг;

1.7.Монросцветмет компанийн үл хөдлөх хөрөнгийн татвар 33.4 сая төгрөг, ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн төлбөр 157,5 сая төгрөг, газрын төлбөр 21.5 сая төгрөг, ус рашаан ашигласны төлбөр 52 сая төгрөг;

1.8.Шижир алт компанийн байгаль орчны зардал 43,6 сая төгрөг;

1.9.Чинхуа МАК нарийн сухайт компанийн хандив 3356,7 сая төгрөг;

1.10.Гацуурт компанийн зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар 1780 сая төгрөг, ус рашааны төлбөр 28,9 сая төгрөг;

1.11.Монполимет компанийн орлогын албан татвар 38,8 сая төгрөг, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр 40,6 сая төгрөг, рашаан, ус ашигласны төлбөр 106 сая төгрөг, гадаад ажилтан, ажилчны ажлын байрны төлбөр 22,9 сая төгрөг, байгаль орчны зардалын 444 сая төгрөг;

1.12.Айвенхоу майнз компанийн хандив 79 сая төгрөг;

1.13.Анхай интернэшнл компанийн хандив 24 сая төгрөг;

1.14.Петрочайнэ дачин тамсаг компанийн газрын төлбөр 318 сая төгрөг, хандив 117,8 сая төгрөг, байгаль орчны зардал 162 сая төгрөг;

1.15.Багануур компанийн туёгай зөвшөөрлийн төлбөр 68,5 сая төгрөг, газрын төлбөр 190 сая төгрөг;

1.16.Эрдэс холдинг компанийн ой түлээний төлбөр 43,2 сая төгрөг, байгаг орчны зардал рдэс холдинг компанийн ой түлээний төлбөр 43,2 сая төгрөг, байгаг орчны зардал 340,8 сая төгрөг;

1.17.Шинь шинь компанийн гааадын мэргэжилтэн, ажилчны ажлын байрны төлбөр 202 сая төгрөг;

1.18.Монгол газар компанийн гаалийн татвар 20,2 сая төгрөг, тусгай зөвшөөрлийн төлбөр 73,7 сая төгрөг, хандив 164 сая төгрөг, байгаль орчны зардал 88,3 сая төгрөг;

1.19.Жамп компанийн ус ашигласны төлбөр 33,6 сая төгрөг, байгаль орчны зардал 299 сая төгрөг;

1.20.Өрмөн-Уул компанийн ашигт малт малын нөөц ашигласны төлбөр 22,3 сая төгрөг;

1.21.Гоби коул энерги компанийн хандив 133 сая төгрөг;

1.22.Шарын гол компанийн газрын төлбөр 43 сая төгрөг;

1.23.Сонор трэйд компанийн орлогын албан татвар 25,9 сая төгрөг;

1.24.Тунсинь компанийн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр 472 сая төгрөг;

1.25.Эрэл компанийн газрын төлбөр 127,7 сая төгрөг;

1.26.Уулс замар компанийн газрын төлбөр 22,8 сая төгрөг;

1.27.Тэн хун компанийн гадаадын ажилтан ажилчны байрны төлбөр 28,4 сая төгрөг.

2. Тайлан гаргахад оролцож байгаа Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Татварын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Ашигт малтмалын газар, Газрын тосны газар, Хөдөлмөр халамж, үйлчилгээний газар болон аймаг, сумдын удирдлага, холбогдох компаниудын удирдлагад тооцооны зөрүүнүүдийг тодорхой болгох талаар ажлын хэсгийн гишүүд, ажлын алба хамтран ажиллах, бүх талын дэмжлэг үзүүлэх нь зүйтэй гэж үзэв.

3. Тайланг компани тус бүрээр, татвар, төлбөрийн төрөл бүрээр нь нэгтгэн тайланд хавсаргах нь зүйтэй гэж үзэв.

4. Хандив тусламжийн жагсаалтыг компани, яам, агентлаг, аймаг, сумаар нь тодорхой гаргаж тайланд хавсаргахыг консорциумд санал болгов.

5. Улаанбаатар аудит корпораци, Хаарт нээрс аудитын компаниудын консорциум 14 хоногийн дотор тооцооны зөрүүнүүдийн шалтгааныг тодорхой болгон, ажлын хэсгийн хуралдаан дээр гишүүдийн гаргасан саналыг судалж, холбогдох тайлбарыг тайланд тусгаж, эцсийн тайланг гаргасаны дараа, ажлын хэсгийн гишүүдэд и-мэйлээр, эсхүл тайланг танилцуулан зөвшөөрөл авч, эцсийн тайланг Үндэсний зөвлөлд оруулан батлуулахаар тогтов.

Б.Долгор: Үлдэж байгаа 3 асуудлуудын хувьд танилцуулга сонсохгүйгээр шууд саналуудаа сонсьё.

II.ХЭЛЭЛЦСЭН нь: ОУИТБС-ын олон улсын удирдах хорооны шийдвэрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний төсөл

Б.Долгор: Хоёрдугаар асуудлын хувьд, манай улс олон улсын удирдах хорооны 4 дүгээр сарын 15-ны хурлаас “шаардлагыг хангахад ойртсон орон” гэсэн статустай болсон байгаа. Тэгээд бидэнд тодорхой хугацаатай ажлуудыг хийхийг үүрэг болгосон байгаа. Одоо бид үүн дээр ажиллах төлөвлөгөөгөө хэлэлцэх гэж байна. Энэ ажлын төлөвлөгөөн дээр нэмж хасах санал байна уу?

Б.Пүрвээ: Төлөвлөгөөний 3 дахь хэсэг дээр судалгаа авна гээд манай нэр орчихсон байна л даа. Бидний хувьд бас хүндрэлтэй санагдаж байна. Үүнийг бид нараас биш ажлын алба өөрийнхөө базаас гаргачихаж болдоггүй юмуу?

Ш.Цолмон: Бид бололцооныхоо хэрээр бас байгууллагуудын мэдээллийг цуглуулдаг. Урьд нь 200-гаад компаниудын судалгаа гаргасан, та бүхэнд ч бас явуулсан. Энэ хүрээндээ л зарим мэдээлэл нь шаардлага хангахгүй байгаа учраас үнэн зөв байдлыг дахиж тодруулах шаардлагатай байгаа юм. Тийм учраас холбогдох байгууллагуудыг оролцуулахгүй бол болохгүй байна.

Б.Долгор: Үүн дээр төрийн байгууллагуудын оролцоо хэрэгтэй байгаа юм. Ажлын албанаас зарим зүйлийг өөрсдөө хийхэд хүндрэлтэй байгааг ойлгох хэрэгтэй.

Н.Дорждарь: Би баталгаажуулалтын талаар тодруулга хийе. Нэгдүгээрт, олон улсын удирдах хорооны шийдвэр дотор наймдугаар үзүүлэлт дээр дахин үнэлнэ гэсэн байгаа. Тэгэхээр бидний дахин шалгуулах үзүүлэлт бол 5 биш 6 болсон гэсэн үг. Хугацааны хувьд, манайд 6 сарын хугацаа өгсөн, 10 дугаар сарын 15 хүртэл гэсэн үг. Тэр болтол үнэлгээгээ хийлгэсэн байх ёстой. Практик талаас нь харахад, удирдах хорооны хурал 10 дугаар сарын 15, 16-нд болно. Харин төлөвлөгөөнд 10 сарын эхээр үнэлэх багийг ирэхээр тусгасан байна. Тэгэхээр энэ бол бүтэхгүй гэдэг нь ойлгомжтой. Тэгэхээр үнэлгээ хийлгэх талаар төлөвлөгөөн дээрээ яаж тусгах вэ гэдгээ бодолцох хэрэгтэй байх. Миний хувьд ингэж бодож байна. Тайлан дээр зөвхөн нөөцийн төлбөр, тусгай зөвшөөрлийн төлбөрөөр компаниудын материаллаг төлбөрийн хэмжээг тогтоох санал тусгагдсан байна. Тогтвортой байдлын гэрээтэй гэх мэтээр нөөцийн төлбөр төлдөггүй компаниудын хувьд яах вэ гэсэн асуулт гарч ирээд байна. Гаалийн хураамжаас бусад бүх хураамжийг хасах гэсэн саналыг би зөвшөөрөхгүй байгаа. Хураамж гэдэг бол бага хэмжээтэй ч гэсэн бүртгэгдэх ёстой гэж бодож байна. Мөн улсын төсвөөс 2009 оны тайлангийн нэгтгэлийг санхүүжүүлэх асуудал юу болж байна вэ?

Э.Сумъяа: Наймдугаар асуудлын хувьд, бид хуулийн ажлын хэсэг гаргаад ажиллаж байгаа. Хуулийн төслийг 2010 оны 7 дугаар сарын 30-ны дотор боловсруулах ёстой. Санхүүжилтийн хувьд бол Ерөнхий сайдын гарын үсэгтэй бичиг Сангийн яаманд очсон. Энэ жилийн төсвийн тодотголд бол орж амжихгүй харин дотоод нөөцийнхөө хүрээнд санхүүжилтийг зохицуулна гэдгээ С.Баярцогт сайд, Д.Баттөр дарга нар хэлээд байгаа. Энэ асуудлаар Хүрэлчимэг Сангийн яаман дээр байнга очиж сураглаж байгаа. Тэгэхээр ямар ч байсан шийдвэрлэж өгнөө л гэсэн хариуг өгдөг гэж байгаа. Бид нар энэ 2008 оны тайлангаа гаргачихвал бас Сангийн яамаар энэ асуудлыг шийдвэрлүүлэхэд дээрээ хүч нэмэх гээд байгаа юм. Баталгаажуулалтын хугацааны талаар хамгийн сүүлийн 10 дугаар сарын 15-наас өмнө гээд л тавьсан байгаа. Одоо олон улсын нарийн бичгийн дарга нарын газраас хүн ирнэ. Тэр хүнтэй уулзахад ер нь тодорхой болох байх.

Ш.Цолмон: Одоо олон улсын нарийн бичгийн дарга нарын газраас Ионес Моберг гэдэг хүн ирнэ. Ажлын хэсгийн гишүүдтэй уулзах байх, бас нэлээд зүйл тодорхой болох байх. Манайхыг материаллаг түвшингээ тогтоож чадаагүй гээд саяын аудит хийж байгаа Хаарт Нээс компанийн хүн шүүмжилсэн. Энэ нь

материаллаг бус түвшний зөрүүнүүдээ хаяад томоохон зөрүүнүүдээ тодруулаад явсан нь дээр гэсэн үг. Тэгэхээр би үүний дагуу тооцоо гаргаснаа та бүхэнд хүргүүлээ.

Б.Пүрвээ: Материаллаг түвшин гэж ярих юм бол хуулиндаа үүнийгээ оруулж өгөх хэрэгтэй.

Б.Долгор: Материаллаг түвшин гэсэн ойлголтоо одоо бол түр зуур орхиод хуулиндаа оруулж өгвөл яасан юм бэ? Бид энд одоо материаллаг зөрүүний хэмжээ ийм тийм байна гээд яриад яах вэ. Үндэсний зөвлөлөөр орж байж эцсийн байдлаар шийдэгдэнэ. За энэ асуудал дээр өөр санал байхгүй бол төлөвлөгөөг сайшаагаад цааш нь Ерөнхий сайдаар батлуулахаар тогтёе.

ШИЙДВЭРЛЭСЭН нь: ОУИТБС-ын олон улсын удирдах хорооны 2010 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний төсөлд хуралдаан дээр гишүүдийн гаргасан саналыг тусган Монгол Улсын Ерөнхий сайд, Үндэсний зөвлөлийн даргаар батлуулж ажиллахыг Ерөнхий сайдын ахлах зөвлөх Б.Долгорт даалгав.

III.ХЭЛЭЛЦСЭН нь: ОУИТБС-ыг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратегийн төсөл

Б.Долгор: Дунд хугацааны стратеги дээр санал байна уу?

Б.Пүрвээ: Ажлын алба нь энэ тайлангаа өөрөө гаргадаг. Тоо, мэдээллээ өөрсдөө цуглуулаад тайлангаа хийдэг баймаар байгаа юм.

Э.Сумъяа: Ажлын алба бол оролцогч 3 талаас хараат бусаар тэнцвэртэй үйл ажиллагаа явуулах ёстой юм. Түүнээс төрийн өмнөөс тайлан гаргаад байвал зарчим нь алдагдана. Харин бид Ажлын албаа өргөжүүлэхээр бас төлөвлөсөн юм байгаа.

С.Мягмардаш: Энэ 11.4.2 дээр төрийн байгууллагын болон нутгийн захиргааны байгууллагын ажлын байрны тодорхойлолт, үр дүнгийн гэрээн дээр Сангийн яам хариуцна гэжээ. Энэ ингээд биччихдэг гэтэл бидэнд тийм эрх нь байхгүй болохоор хэцүү л юм байна. Бас 11.5.3 дээр шинээр батлагдсан хуулийн дагуу Сангийн яам зохион байгуулалтыг хариуцна гэжээ. Бодвол хуулин дээр тодорхой заах юм байгаа биз дээ.

Н.Эрдэнэцэцэг: 11.5.5 дээр 2012 оноос гэснийг 2011 гэж наашлуулах саналтай байна.

Б.Долгор: За өөр санал байхгүй бол гишүүдийн саналыг тусгаад стратегийн төслийг сайшаагаад цаашаага батлуулъя.

ШИЙДВЭРЛЭСЭН нь: 1. ОУИТБС-ыг Монгол улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратегийн төслийг хэлэлцэж дэмжээд хуралдаан дээр гишүүдийн гаргасан саналыг тусган Үндэсний зөвлөлд оруулж батлуулахыг Ажлын хэсгийн ахлагч Б.Долгорт даалгав.

Б.Долгор: За өөр санал байна уу. Өөр санал байхгүй бол үүнийг сайшаагаад гишүүдийн гаргасан саналыг тусгаад цааш явъя. Тайлангийн маягтын төслийн талаар хэлэлцэнэ. Би Ерөнхий сайд руу яаралтай явах шаардлагатай болсон тул Сумъяа гуай үргэлжлүүлээд хурлаа даргалаад явчих. Ирцийн хувьд иргэний нийгмийн байгууллагуудын ирц хангалтгүй байна. Ажлын алба гишүүдийн ирц дээр анхаарч ажиллахыг анхааруулж байна. Хуралдаа ирж асуудлуудтайгаа танилцахгүй, саналаа хэлэхгүй мөртлөө гудамжинд янз бүрийн зүйл яриад яваад байдаг шүү, зарим иргэний нийгмийн төлөөлөл. Бас хийж байгаа ажлуудыг ил тод мэдээлэх, чадавхийг бэхжүүлэх тал дээр ихээхэн ажлуудыг хийх шаардлагатай байгаа.

Ү.ХЭЛЭЛЦСЭН нь: ОУИТБС-ын тайлан гаргах маягтуудын төсөл

Э.Сумъяа: Маягт боловсруулах ажлын хэсэг гарсан байгаа. Хуучнаасаа нэлээд дэлгэрүүлсэн байгаа. Төсвийн тухай хуульд орон нутагт илүү их эрх мэдэл өгөх талаар өөрчлөлт орж магадгүй байгаа учраас хүлээнэсэн байсан. Гэтэл үүнийг бас хурдан гаргах шаардлага бидний ажилд гарч ирлээ. Энэ талаар та бүхэн саналаа хэлээчээ

Ш.Цолмон: Би тайлбар хийе. Бид урьд нь 4 маягттай байсныг 6 маягттай болж өөрчилсөн байгаа. Олборлогч компаниуд Маягт-1-ээр, хайгуулын компаниуд Маягт-2-оор, аймаг, нийслэл, төрийн захиргааны байгууллагууд Маягт-3-аар, Ашигт малтмалын газар, Цөмийн энергийн газар, Байгаль орчин аялал, жуулчлалын яам, Гаалийн ерөнхий газар, Хөдөлмөр халамж үйлчилгээний газар, Татварын ерөнхий газар, Газрын тосны газар, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Төрийн өмчийн хороо зэрэг газрууд Маягт-4-өөр, Засгийн газрын нэгдсэн тайлан Маягт-5-аар, Ашигт малтмалын газар, Цөмийн энергийн газар, Газрын тосны газрууд бүтээгдэхүүний үйлдвэрлэлт борлуулалт, тусгай зөвшөөрлийн төлбөр гэх мэтээ Маягт-6-аар тус тус тайлагнах юм. Мөн шинээр нэлээд олон татварууд нэмэгдсэн байгаа. Тухайлбал, нийгмийн даатгалын шимтгэл, үйл ажиллагааны орлогын албан татвар, хөрөнгийн орлогын албан татвар, хөрөнгө борлуулсны орлогын албан тавар, нэмэгдсэн өртгийн албан татвар гэх мэт. Хайгуулын компанийн туршилтын олборлолтыг тайланд тусгахаар оруулж өгсөн байгаа. Гуравдугаар маягтан дээр Сангийн яамтай дүрэм, журмын асуудлаа нэлээд сайн ойлголцож хийсэн. Хамгийн гол нь тайлан гаргагч нартаа нягтлан бодох бүртгэлийн мөнгөн сууриар бүртгэсэн тоог тайлан дээр тавина гэдгийг маш сайн анхааруулж өгөх ёстой юм. Тэгээд энэ маягтууд дээр аудитын дүгнэлт хавсаргагдаж явна гэж заавар дээр нь тусгасан. Товчхондоо гэвэл иймэрхүү байна.

н.Бат-Эрдэнэ: Надад нэг санал байна. Энэ тайлан дээр хүн амын орлогын албан татварыг оруулж өгвөл яасан юм бэ. Манай компани гэхэд 2 тэрбум төгрөгийн хүн амын орлогын албан татварыг төлсөн. Энэ бол том дүн.

Э.Сумъяа: Манай барьж байгаа олон улсын заавар дээр хүн амын орлогын албан татварыг оруулахгүй гээд заасан байдаг юм.

Н.Алгаа: Ер нь элдэв хураамж, төлбөрийг энэ тайланд аль болох оруулмааргүй байна шүү дээ. Юу ч хамаагүй хийгээд байдаг сав шиг элдэв хураамж татварыг оруулчихаад дараа нь учир нь ч олдохгүй баахан зөрүү гараад

байгаа юм шүү дээ. Олборлох үйлдвэрлэлийн томоохон татвар төлбөрүүдээ л оруулъя л даа. Тэр бууны татвар, онцгой албан татвар, торгууль гэх мэт юмнуудыг тайлагнаад ямар ч ач холбогдол гарахгүй. Хамаатай, онцлогтой юмаа л тайлагнаа л даа. Тэр бүтээгдэхүүний борлуулалтыг оруулах хэрэг байгаа юм уу? Бид маягттайгаа ноцолдсоор байгаад 3 жил боллоо. Ам нь боогддоггүй нэг ууттай. Жил бүр өөрчлөөд, 4 байсан маягт 6 болоод дараа нь 10 болох уу. Энэ бол ил тод болж байгаа биш хүнд суртал гэж би хэлнэ.

Ш.Цолмон: Энэ борлуулалт бол стратегитай холбогдож орж байгаа юм. Бид бас ирээдүйд хийх ажлаа өнөөдөр төлөвлөж байгаа юм.

Н.Дорждарь: Ялангуяа гадаадын компаниудаас торгуулиа оруулж өгөөчээ гэсэн хүсэлт гаргаад байгаа. Нэг төрийн байгууллагын нөхөр ирээд танайхыг торголоо гээд баахан торгууль бичээд явдаг, эсхүл алтыг нь аваад явчихдаг гэж байгаа юм. Бороо гоулд ч гэсэн ХАОАТ-аа харуулмаар байна гэж байна. Компанийн талаас харвал зөв шүү дээ. Бүх л төлсөн юмаа тайлагнамаар байгаа.

Н.Алгаа: Энэ чинь төрийн байгууллагын дарамтнаас болж л компани тэгж байгаа шүү дээ. БОАЖЯ-ны төвлөрүүлсэн зардал гэж тэр талбайгаар нь үржүүлдэг тийм юмаар яах юм бэ?

Б.Пүрвээ: Бүгдээрээ үүн дээр маргаад яах юм бэ? Тэр сайн хэрэгжүүлээд байгаа гэгддэг Азербайджан энэ тэр нь яадаг юм бэ гэдэг мэдээллийг бидэнд өгөөчээ. Би бол Алгаа гуайтай санал нэгдэх гээд байна. Хийж байгаа ня-бо нарынх нь ч үстэй толгой арзайж байгаа байх.

Ш.Цолмон: Би энэ бусад улс орнуудын тайлангийн маягтыг та бүхэнд явуулъя.

Н.Дорждарь: Компаниуд аль болохоор төлснөө ил гаргамаар байгаа юм. Хэрэв энэ тайлангаар нийт татварын 40, 50 хувь нь ил болох юм бол үүнийг хэрэгжүүлж яах юм бэ? Бас тайланд оруулаагүй татвар, төлбөрүүд рүү но-той юмаа бичээд сууж байвал яах вэ? Тэгэхээр би бол тайланд орох татварын тоог цөөрүүлэх талаар санал нийлэхгүй байна. Тэр Азербайжан эд нарын хувьд бол манайхаас хамаагүй доор нөхцөлд диктатурт байгаа, тайлан нь ч сайн тайлан биш тийм газартай хөөцөлдөөд яах вэ. Бид Монголын хөрсөнд л санаачлагыг буулгах гэж байгаа шүү дээ.

А.Эрдэнэдорж: Газрын тосны компани 20-иод компани байдаг. Гэтэл ганцхан манайхыг л шалгаад байх юм. Бусад компаниуд ч гэсэн бас зөндөө л юм төлж байгаа шүү дээ.

Ш.Цолмон: Ашигт малтмалын хуулийн 48,10-т манай заалт байгаа. Гэтэл хайгуулын болоод байгалийн хий, газрын тосны салбарт хамаагүй гээд заасан байгаа учраас бид бас өөдөөс нь юм хэлж чадахгүй болоод байгаа юм.

Э.Сумъяа: Газрын тосны газраас Оюун ирсэн байна. Эрдэнэдорж, Оюун бид 3 газрын тосны компаниудыг тайланг гаргах, татвар төлсөн байдлыг ил болгох талаар маягтын төсөл боловсруулаа. Манай маягт бол сайн маягт, харин бусад хууль тогтоомж, хугацаа энэ тэртэй уялдуулах тал дээр анхааръя. Маягтыг

аудитлуулна гэхээр бас компаниа хүндрүүлэх гээд байгаа юм. Тэгэхээр удирдлагын хариуцлагын захидал хамт ирүүл гэдэг юм уу?

Б. Пүрвээ: Үүнийг аудит хийсэн аудитын компанийн дүгнэлттэй хамт ирүүл гэсэн нь дээр байх. Дараа нь аудитын компани нь бас худал тайлан гаргасан бол хариуцлага хүлээнэ шүү дээ.

Э.Сумъяа: За бүгдээрээ нэлээд олон талаас нь ярилаа. Та нар тайлан боловсруулах ажлын хэсэг дээрээ сайн ярилц. Тэгээд том ажлын хэсэг рүүгээ нэг явуулаад дараа нь Үндэсний зөвлөлд оруулъя.

ШИЙДВЭРЛЭСЭН нь: ОУИТБС-ын тайлан гаргах маягт, түүнийг гаргах зааврын төслийг хэлэлцээд хуралдаан дээр гишүүдийн гаргасан татвар, төлбөрийн тайлагнах маягт, журамтай адил болгох, төлбөр, хураамжийг нэмэх, газрын тосны салбараар тусдаа маягт боловсруулах зэрэг саналыг тусган Үндэсний зөвлөлд танилцуулахаар бэлтгэхийг маягт, заавар боловсруулах ажлын хэсэгт даалгав.

Ажлын хэсгийн хуралдаан 18 цаг 00 минутад дуусав.

Хурлын тэмдэглэлтэй танилцсан:

Ерөнхий сайдын ахлах зөвлөх,
Ажлын хэсгийн ахлагч

Б.Долгор

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

Ажлын албаны санхүүгийн ажилтан

Т.Хүрэлчимэг